

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ДОТООД АУДИТЫН АЛБА**



**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

**Аудитын нэр: АЛТАНБУЛАГ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**Аудитад хамрагдсан жил: 2024 эхний хагас жил**

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “АЛТАНБУЛАГ СУМЫН ТТЗ”**

**АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “АЛТАНБУЛАГ СУМЫН ТТЗ”**

**АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ**

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.09.02-2024.09.15**

**АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2024**

**Тайланг бэлтгэсэн:**

**Дотоод аудитын нэгжийн  
удирдлагын дарга**

**Сэлэнгэ аймгийн Засаг  
даргын дэргэдэх**

**Санхүүгийн хяналт,  
дотоод аудитын албаны  
дарга, СХШУАБ**

**Т.Одсүрэн**

**Аудитын багийн  
гишүүн:**

**Дотоод аудитор  
Г.Дорждэрэм,**

**Огноо: 2024 оны 09 дугаар  
сарын 06 өдөр**

**Сүхбаатар сумын 2  
дугаар баг.**

**Нутгийн удирдлагын II  
байр**

**[selenge@sankhuuaudit.se.gov.mn](mailto:selenge@sankhuuaudit.se.gov.mn)**

**1. ТАНИЛЦУУЛГА**

**2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,**

- 2.1 Аудитын зорилго
- 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
- 2.3 Аудитын арга аргачлал
- 2.4 Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд
- 2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

**3. БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, САЙН  
ТУРШЛАГА, ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТҮҮХ**

- 3.1 Дотоод аудитад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл, танилцуулга
- 3.2 Сүүлийн 2 жилд хяналт шалгалтад хамрагдсан байдал, өмнөх шалгалтын талаар

**4. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА,  
ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА,  
ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ТАЛААР**

- 4.1 Байгууллагын сайн туршлага
- 4.2 Засаглалын талаар
- 4.3 Эрсдэлийн удирдлагын талаар
- 4.4 Дотоод хяналтын талаар

**5. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

- 5.1 Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт
- 5.2 Эдийн засаг, төсөв санхүүгийн ажил, арга хэмжээ

**6. ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНИЙ  
НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ**

**7. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР БОЛОН  
ЗААВАР, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ.**

**8. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, ИРГЭНТЭЙ  
БАЙГУУЛСАН ГЭРЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ.**

**9. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТБОНХБАУХАТ  
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

**10. АУДИТЫН ҮР ДҮН**

- 10.1 Илэрсэн асуудлууд

**11. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

## 1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 07 дугаар сарын 8-ны өдрийн 06 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг "Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх" гэж тодорхойлсон байна. Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэмсоёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамруулна.

Үүнд:

- *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;*
- *Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт,*
- *Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилголоо, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт*
- *Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*
- *Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт.*
- *Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих*

- Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт үр дүн
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

#### **Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:**

Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

#### **2.3 Аудитын арга, аргачлал**

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

#### **2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- СТОУС, НББОУС болон бусад станд
- артууд
- Бусад хууль, эрх зүйн актууд

#### **2.5.Аудитын хугацаа, бүрэлдэхүүн**

Дотоод аудитыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 09 дугаар сарын 23-ний өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, дотоод аудитор Г.Дорждэрэм нар гүйцэтгэв.

### **3. Байгууллагын талаарх ойлголт, сайн туршлага, өмнөх шалгалтын түүх.**

#### **3.1 Дотоод аудитад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл, танилцуулга.**

Алтанбулаг сум Засаг даргын тамгын газрын барилга нь 7422м<sup>2</sup> бүхий талбайтай, 2 давхар барилга 2018 онд ашиглалтад орсон. Орон нутгийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны төвлөрсөн системд холбогдсон байна.

Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэл Улаанбаатартай холбосон олон улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбогдсон. Мөн тус сумын нутаг дэвсгэр дээр Олон улсын авто замын шалган нэвтрүүлэх боомт байрладаг. Энэ боомт нь Монгол Улс болон ОХУ-ын хоорондын худалдаа, тээвэрлэлтийн гол цэг юм.

**Хүснэгт №1**

Шалгалтад хамрагдсан хугацааны хөрөнгө мөнгө захиран зарцуулалтын байдал:			
№	Харилцах дансны дугаар	1 дүгээр гарын үсэг	2 дугаар гарын үсэг
1	РД: 9057439 ОНЕО 100130100910	Засаг дарга Н.Отгонцогт	Сумын Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Саранцэцэг

**3.2. Сүүлийн 2 жилд хяналт шалгалтад хамрагдсан байдал, өмнөх шалгалтын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хуульд заасан үндэслэлээр 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2 удаа гүйцэтгэж бие даасан дүгнэлт өгсөн ба 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшууллыг илүү олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй, төлбөрийн цахим баримт, ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоосон зэрэг нийт 55,879.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Өөрчлөлтэй дүгнэлт авсан ТТЗ, ТШЗ захирагч нарын үйл ажиллагаанд Засаг даргын нэгдсэн удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.

Харин 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 35,093.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 668.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 17,650.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 16,775.5 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс эхний хагас жилийн байдлаар акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 68.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт; дотоод аудитын албанаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Алтанбулаг сумын ТТЗ-ийн харьяа сумын ЗДТГ, ИТХ-д санхүүгийн хяналт шалгалт, ХХС-ийн 2022-2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудит болон шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжүүдийг өгсөн байна . Үүнд:

- ✓ Алтанбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 35,681,9 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс цаашид дахин давтан гаргахгүй байх санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 4,844,6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 20,640,4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 10,196.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр,
- ✓ Алтанбулаг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 7,178.1 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 1,190.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 5,519.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 468.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүл
- ✓ Хоршоог хөгжүүлэх сангийн 2022-2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар нийт 318,175.1 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 2,714.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 154,785.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 160,648.8 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг тус тус өгсөн байна.
- ✓ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт 1 дүгээр улиралд мэдээлэ байршуулалт 80.2 хувьтай байсан бол 2 дугаар улиралд 97.7 хувьтай болж төсөв, санхүүгийн ил тод байдал сайжирсан байна.

#### **4. Байгууллагын сайн туршлага, засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын талаар.**

##### **4.1 Байгууллагын сайн туршлага**

Тус суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын дэд бүтцийг хилийн боомттой нэгдсэн байдлаар шийдэх зорилгоор 3,980,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Жишиг сум" төслийг 2022 оноос хэрэгжүүлэн гүйцэтгэгчээр "Бажа Мандал" ХХК шалгарсан ба 2024 оны эхний хагас жилийн байдлаар ажлын гүйцэтгэл 87.4 хувьтай байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй "Жишиг сум" төсөлд тус аймгийн анхдагч сум болсноороо онцлог юм.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга Н.Отгонцогтын ивээл дор, АБТА, Алтангадас одонт Н.Гүнчин багшийн нэрэмжит "Төрийн албан хаагчид"-ын дунд "Үндэсний бичиг"-ийн олимпиадыг хоёр үе шаттай зохион байгуулж тус олимпиадад сумын 8 төрийн байгууллагын 56 албан хаагч оролцож, монгол бичвэрийн үзэсгэлэн гаргаж, үндэсний бичгийн өв соёлыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

Төрийн албаны хаагчдын ажиллах нөхцөл бололцоонд дэмжлэг үзүүлэх зорилгоор төсвийн 5 байгууллага хүүхэд хамгаалах зөвлөлийг байгуулсан бол ЗДТГ-ын албан хаагчид өөрсдийн нөөц бололцоогоор хүүхэд хамгаалах өрөөг анхлан санаачилж хийсэн байна.

##### **4.2 Засаглалын талаар**

Алтанбулаг сумын ТТЗ нь Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль, Засгийн газрын тогтоол, хөтөлбөр, бодлого шийдвэр, албан даалгавар, Сэлэнгэ аймаг,

Алтанбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн асуудлын талаарх төлөвлөсөн зорилтоо биелүүлж, тавьсан бодлого зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 86.2 хувь, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 81.3 хувь, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 79.2 хувь, аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 72.3 хувь, "Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 72.7 хувьтай хэрэгжүүлж мэдээ тайланг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан байна.

#### **4.3 Эрсдэлийн удирдлагын талаар**

Эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд эрсдэлийн удирдлагын бодлого, журамгүй, байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг тодорхойлоогүй, энэ талаарх нэгдсэн ойлголт байгаа ч эрсдэлийг урьдчилан тооцоолж бүртгэж үнэлэх арга хэмжээ зохион байгуулаагүй байна. Мөн санхүүгийн үйл ажиллагаа болон эрх бүхий албан тушаалтнаас гарах тушаал шийдвэрийн боловсруулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй нь эрсдэлийн удирдлагыг түвшин сул байгааг илэрхийлж байна.

#### **4.4 Дотоод хяналтын талаар**

Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй, дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй, хариуцсан ажилтангүй, зөвхөн байгууллагын өдөр тутмын болон санхүүгийн ажил гүйлгээг хянаж баталгаажуулах байдлаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа нь дотоод хяналтыг сулруулж байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой байна.

### **5. Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт**

#### **5.1 Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн дүнгийн талаар**

Тус сумын засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай 17 зорилт, 286 арга хэмжээг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Эхний хагас жилийн байдлаар 17 зорилт, 286 дэд арга хэмжээний биелэлт 81.3 хувьтай, "В үнэлгээтэй" тайлагнагдсан байна.

#### **5.2 Эдийн засаг, төсөв санхүүгийн ажил, арга хэмжээ**

##### **5.2.1 Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт**

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн "Алтанбулаг сумын 2024 оны төсөв батлах" тухай 119 дүгээр тогтоолоор 716,919.4 мянган төгрөгийн татварын орлого, 81,662.5 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 798,081.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

Эхний хагас жилийн байдлаар 463,715.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 562,486.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 98,770.5 мянган төгрөгөөр буюу 121.5 хувиар давж биелсэн байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын ангилал нэр төрлөөр дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

**Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого**

*/мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Орлогын албан татвар</b>	<b>422,883.70</b>	<b>496,740.00</b>	<b>73,856.30</b>	<b>1,396.83</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	125,434.70	172,644.60	47,209.90	137.6
Үйл ажиллагааны орлого	30,688.30	199,725.70	169,037.40	650.8
Хөрөнгийн орлого	18,229.80	16,351.70	(1,878.10)	89.7
Хөрөнгө борлуулсны орлого	18,229.80	25,596.90	7,367.10	140.4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,649.80	2,244.50	(1,405.30)	61.5
Бууны албан татвар	400.2	435.00	34.80	108.7
Малын тоо толгойн албан татвар	25,000.20	4,527.50	(20,472.70)	18.1
Улсын тэмдэгтийн хураамж	4,999.80	2,826.00	(2,173.80)	56.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,999.80	537.4	(4,462.40)	10.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.20	5,071.40	(4,928.80)	50.7
Газрын дуудлага худалдаа	42,564.00	13,762.30	(28,801.70)	32.3
Ойн нөөц ашигласны төлбөр	133,731.70	53,017.00	(80,714.70)	39.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,292.60		(2,292.60)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	2,662.80		(2,662.80)	-
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>40,831.80</b>	<b>65,746.00</b>	<b>24,914.20</b>	<b>161.02</b>
Торгуулийн орлого	31,302.60	63,123.9	31,821.30	201.7
Төсөв байгууллагын өөрийн орлого	250.2	763.2	513.00	305.0
Бусад орлого	9,279.00	1,858.9	(7,420.10)	20.0
<b>Нийт дүн</b>	<b>463,715.50</b>	<b>562,486.00</b>	<b>98,770.50</b>	<b>121.3</b>

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Төсвийн орлого давж биелсэн нь:**

- Засгийн газрын 2024 оны 82, 84 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор ХХОАТ-ын орлого 47,209.9 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 169,037.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь, "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2024 онд иргэн бүрд, компанийн 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 285.0 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилснаас шалтгаалсан байна.

- Хөрөнгө борлуулсны орлого 7,367.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь орон сууцны ипотекийн зээлийг эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотой байна. олгосноос,
- Бууны албан татварын орлого 34.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь, өнгөрсөн оны дутууг төлүүлсэн орлого төлөгдсөнөөс,
- Торгуулийн орлого 31,821.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь, Интератур ХХК-д, Нешнелиженсы ХХК-д татварын хяналт шалгалтыг хийж төлбөрийн акт тогтоосон нь төлөгдсөнөөс тус тус голлон шалтгаалсан байна.

#### Төсвийн орлого тасарсан нь:

Тайлант жилийн эхний хагас жилийн байдлаар төсөвт төвлөрүүлэх орлого 21.5 хувиар давж биелсэн боловч нэр төрлөөр нь шалгахад дараах орлогууд тасарсан байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлого 20,472.7 мянган төгрөгөөр тасарсан нь өвөлжилт хүндэрч мал их хорогдсонтой холбоотойгоор малчдын орлого буурснаас шалтгаалсан байна.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 4,928.8 мянган төгрөгөөр тасарсан нь,, Улсын хилээр нэвтрэх иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалсан байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 28,801.7 мянган төгрөгөөр тасарсан 2024 оны газрын төлөвлөгөөтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.
- Ойн нөөц ашигласны төлбөр 80,714.7 мянган төгрөгөөр тасарсан нь, аймгийн ИТХ-аас 2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар тогтоох тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг хангалтгүй хийсэн зэргээс төсвийн орлого тасрахад голлон нөлөөлсөн байна.

#### 5.2.2 Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвийн гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар 73.0 хувьтай буюу 987,470.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Эхний хагас жилд зарцуулсан хөрөнгийг зардлын эдийн засгийн бүлгийн ангиллаар дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Биелэлт /хувь/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,353,395.90	987,521.98	230,873.9	73.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	971,540.60	841,479.56	130,061.0	86.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	930,264.20	805,977.55	124,286.6	86.6
2101	Цагин хөлс болон нэмэгдэл урамшил	446,501.8	385,607.56	60,894.2	86.6

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,110.60	43,207.71	12,902.9	77.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,189.30	280,667.56	10,521.7	96.4
2104	Хангамж, бараа материалын зардал	17,651.40	16,247.71	1,403.7	92.0
2105	Норматив т зардал	701.70	24.40	677.3	3.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,584.40	14,102.65	4,481.8	75.9
2107	Томилолт, зочны зардал	4,415.80	3,690.00	725.8	83.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,163.00	53,716.76	25,446.2	67.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,946.20	8,713.20	7,233.0	54.6
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,276.40</b>	<b>35,502.01</b>	<b>5,774.4</b>	<b>86.0</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>246,855.30</b>	<b>146,042.42</b>	<b>100,812.9</b>	<b>59.2</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>135,000.00</b>	<b>0.00</b>	<b>135,000.0</b>	<b>0.0</b>

**6. Засаг даргын тамгын газрын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилголоо, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт**

Тус сумын ЗДТГ-ын бүтэц орон тооны хязгаарыг 19 байхаар батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар төрийн захиргааны 4 албан хаагчийн орон тоо сул байсан байна.

Энэхүү сул орон тоог нөхөх, хүний нөөцийн бүрдүүлэх зорилгоор Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд сул орон тоог нөхөх хүсэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

- Мал аж ахуйн үржил бүртгэл хариуцсан мэргэжилтний сул орон тоог нөхөх зар төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн боловч нөхөгдөөгүй байна. Одоогоор газар тариалан бэлчээр хариуцсан мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна.
- Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтний сул орон тоог нөхөх зарыг төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Одоогоор хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна.
- Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн сул орон тоог нөхөх зарыг төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн бөгөөд одоогоор нөхөгдөөгүй төрийн сангийн мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна.

**7. Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.**

Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилтийн хүрээнд хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа даган мөрдөж, тогтоол шийдвэрийг биелэлт, үр дүнг тооцож, тайлагнаж, цаг тухай бүр нь дээд шатныхаа байгууллагад хүргүүлсэн байна. Төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг орон нутагтаа зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан байна.

1. Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны А/124 тоот захирамжаар зарим албан хаагчдад зэр дэвүүдийг олгожээ. Энэхүү захирамжтай холбогдуулан Сумын Засаг даргын 2024 оны Б/11 дугаартай захирамж болон Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны Б/07 дугаартай тушаалаар албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг сар бүр олгосон байна.

2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг зохион байгуулж 111 малчдад шинэ хоршоо байгуулах сургалт, зөвлөгөө өгч, 16 шинэ хоршоо байгуулсан.

3. Монгол Улсын Засгийн газрын 279-р тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мал өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж ажилласан. Сумын хэмжээнд 253 малчин өрх болон 134 мал бүхий өрхийн түвшинд 55,957 мянган толгой малд 5,500 тн өвс бэлтгэж өвөлжилтийг малын хорогдол багатай даван туулсан байна.

#### **8. Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт.**

Тужийн нарсны тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаатай хамтран орчны бүсийн 34 өрхийн 102 иргэнтэй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж гэрээ хийсэн байна.

Алтанбулаг сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/15 дугаар захирамжаар ойн санг гэрээгээр эзэмшигч ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэх үйл ажиллагаанд байгаль хамгаалагч хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын захирамжаар “Бүтээлч Алтанбулаг” /ургууля, усалъя/ төслийг ХХҮГазрын даргатай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын “Эрүүл мэндийг дэмжих төв”-тэй гэрээ байгуулан Сургуулийн 60 ажилтныг эрт илрүүлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан байна.

#### **9. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Сумын ОНХС, аймгийн замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр нийт 526,398.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 2,600.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, дутуу хэрэгсэн 489,943.4 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, хэрэгжээгүй 33,855.3 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ байна. Төсөл арга хэмжээг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

Хүснэгт 11. Төсөл арга хэмжээний нэр, санхүүжилтийн дүн /мянган төгрөг/

№	Эх үүсвэр			Хэрэгжсэн байдал
---	-----------	--	--	------------------

		Арга хэжээ	Нийт төсөвт өртөг	2024 онд санхүүжих	Бүрэн хэрэгжсэн		Дууу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
1	Шилжих хөрөнгө оруулалт	10	137,240.3	68,855.3			5	55,000.0	2	13,855.3
2	Шинээр хэрэгжих	3	457,543.4	457,543.4	1	2,600.0	1	434,943.4	1	20,000.0
	<b>Сумын хөрөнгө оруулалтын дүн</b>	<b>10</b>	<b>594,783.7</b>	<b>526,398.7</b>	<b>1</b>	<b>2,600.0</b>	<b>6</b>	<b>489,943.4</b>	<b>3</b>	<b>33,855.3</b>

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авч эрэмбэлэн, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

Сумын ОНХС-аас 2024 онд шинээр хэрэгжүүлэх нийт 3 арга хэмжээнээс эхний хагас жилийн байдлаар 437,543.4 мянган төгрөгийн төсөв өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ “Хилийн цэрэгт мотоцикл худалдаж авах” 2,600.0 мянган төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд худалдан авалтын аргаар,
- ✓ “Хороолол дунд зам барих” 434,943.4 мянган төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулах аргаар тус тус сонгон шалгаруулжээ.

Өмнөх оноос шилжиж ирсэн нийт 68,855.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 50,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ “ДУК машин худалдаж авах” 40,000.0 мянган төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- ✓ Малчдын сургалт, сурталчилгаа, туршлага судлуулах 5,000.0 мянган төгрөгийн малын үүлдэр угсаа сайжруулах 1,000.0 мянган төгрөгийн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах 4,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд худалдан авалтын аргаар тус тус сонгон шалгаруулжээ

## 10. АУДИТЫН ҮР ДҮН

<b>Илэрсэн асуудал 1</b>	Эрсдэлийн удирдлагын бодлого, журамгүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө бага
<b>Бодит байдал:</b> Байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг судлан бүртгэж, үнэлдэггүй, эрсдэлийн бодлого журам байхгүй байна. Эрсдэлийг зөвхөн хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлээр хязгаарлагдаж байна.	

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

- Байгууллагын удирдлагууд эрсдэлийн удирдлагын талаар анхаарал тавьж, хөгжүүлдэггүй, мэдлэг, туршлага дутагдсанаас үүдэн эрсдэлийн удирдлагын тогтолцоо бий болгож чадахгүй
- Байгууллагын удирдлага, албан хаагчид эрсдэлийн талаарх тодорхой ойлголтгүй, дотоод хяналтын ажилтангүй

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

- Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах
- Байгууллагын үнэ цэнэ буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.

**Шийдвэр:**

Байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн илэрсэн эрсдэлүүдийг бүртгэх, уламжлалт болон шинээр үүсэх эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээг авах эрсдэлүүдийг удирдахад чиглэсэн бодлогыг боловсруулан мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<b>Илэрсэн асуудал 2</b>	Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.
--------------------------	--

<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө бага
-------------------------	------------

**Бодит байдал:**

Байгууллагын өдөр тутмын болон санхүүгийн ажил гүйлгээг хянаж баталгаажуулах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагаа хязгаарлагддаг.

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна, 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Байгууллагын дарга болон албан хаагчид дээрх журмыг мөрддөггүй, хууль эрх зүйн мэдлэг дутмаг. Дотоод хяналт явуулахад шаардлагатай хүний нөөц, мэргэжилтнүүдийн дутагдалтай.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

Байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль, тогтоомж, дүрэм журам, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэртэй нийцэхгүй байх, үйл ажиллагааны болон төсөв санхүүгийн эрсдэл, залилангийн эрсдэл үүсэх.

**Шийдвэр:**

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангах, ТТЗ-ийн түвшинд Дотоод хяналтын хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтийн биелэлтийг хангуулж, үр дүнг тооцож байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<b><u>Илэрсэн асуудал 3</u></b>	Эзэн холбогдогч тогтоогдоогүй гэх үндэслэлээр хураагдсан зах зээлийн үнэлгээгээр 18,000.0 мянган төгрөгийн 600м3 зах банзыг худалдан борлуулах шийдвэр гаргасан боловч одоог хүртэл тус орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<p><b>Бодит байдал:</b></p> <p>Хууль бусаар мод бэлтгэсэн байж болзошгүй гэх хэрэгт мөрдөн шалгах явцад хураагдсан зах банзыг Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор хэрэг бүртгэлийн эзэн холбогдогч тогтоогдоогүй гэх үндэслэлээр сумын ЗДТГ-т 600м3 зах банзыг сумын засаг даргын тамгын газарт орлогод авахаар шийдвэрлэсэн байна.</p> <p>Алтанбулаг сумын засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн А/59 тоот захирамжид:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ЗДТГ-т орлогод авах,</li> <li>• тус сумын 1,2,3 дугаар багуудад тус бүр 100м3 банзыг үнэлсэн үнэнээс 62.5 хувийн хөнгөлөлттэй үнээр,</li> <li>• Багийн засаг даргын гаргасан нэр бүхий иргэдэд, мөн “Шинэ Сэлэнгэ” бүтээн байгуулалт, тохижилт үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 200м3 банзыг үнэлсэн үнийн 50 хувиар сумын иргэдэд худалдан борлуулах,</li> <li>• 600м3 зах банз зөөвөрлөсний хөлсөнд 100м3 банзыг олгохоор шийдвэр гаргасан байна.</li> </ul> <p>Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмыг баримталж ажиллаагүй байна.</p> <p>Мөн сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн А/11 тоот тушаалаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сумын орлогод бүртгэж авах шийдвэр гарсан байна.</li> </ul> <p><b>Хэрэгжүүлсэн байдал.</b></p> <p>Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмыг баримтлаагүй, Засаг даргын дэргэдэх Зөвлөл ажиллаагүй, 600м3 зах банзыг сумын орлогод бүртгэж аваагүй шууд 1,2,3-р багуудын засаг дарга нарт хүлээлгэн өгсөн. Хөндлөнгийн үнэлгээний компаниар тухайн банзанд үнэлгээ тогтоолгон 1м3 банзыг 80,000.0 мянган төгрөгөөр үнэлүүлсэн. Гэтэл сумын Засаг даргын А/59 тоот захирамжаар тухайн үнэлсэн үнээс 62,5%-р хөнгөлж, 1м3 банзыг 30,000.0 мянган төгрөгөөр сумын иргэдэд борлуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төвийн багууд болох 1,2-р багуудад тус тус 200м3, хөдөөгийн багт 100м3-г зах банз олгохоор шийдвэрлэсэн байна.</li> <li>• Бүргэдэй 1 дүгээр баг хуваарьт банзаа айл өрхүүддээ тараан өгч банзны төлбөр болох 6,000.0 мянган төгрөгийг ЗДТГ-н нэмэлт санхүүжилтийн данс 100130155408 тоот дансанд 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хийж төвлөрүүлсэн байгаа.</li> <li>• Суварга 2 дугаар баг хуваарьт банзаа айл өрхүүддээ хуваарилсан боловч банзны үнэ 6,000.0 мянган төгрөгийг ЗДТГ-н нэмэлт санхүүжилтийн данс 100130155408 тоот дансанд төвлөрөөгүй байна.</li> <li>• Цөх 3 дугаар баг хуваарьт банзаа айл өрхүүддээ тараан өгсөн боловч банзны үнэ 6,000.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төлбөр бүрэн төвлөрөөгүй, 1,250.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.</li> </ul>	
<p><b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ын 2.1. дах “Эрх бүхий байгууллага, албан тушаалтан албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгөнөөс хохирол нөхөн төлүүлэх, хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг улсын орлого болгох, устгах, бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг харьяа нутаг дэвсгэрийнхээ Засаг даргын дэргэдэх Зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлнэ”, 2.10.3 дах “Хөрөнгийг худалдан борлуулсны орлогоос энэ журмын 2.10.1, 2.10.2 дах заасан зардлыг, эд зүйл, хэрэгслийг худалдан борлуулсны орлогоос энэ журмын 2.10.2 дах заасан зардлыг тус тус хасаад үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлэх” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна</li> </ul>	

**Асуудлын үндсэн шалтгаан:**

"Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ыг баримталж ажиллаагүйгээс ТТЗ буруу шийдвэр гаргасан.

Байгууллагын дотоод хяналт сул

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

Зарцуулах эрхгүй орлогыг (нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснээс) зарцуулах зөрчил үүснэ ТТЗ буруу шийдвэр гаргаснаар ажилчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, ажилчдын ажлын идэвх, ажлын бүтээмж буурч болох юм

**Шийдвэр:**

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хурааж худалдан борлуулах 18.000.0 мянган төгрөгийн өртөгтэй 600 м3 зах банзны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх **төлбөрийн акт** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<b>Илэрсэн асуудал 4</b>	ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой 479,943.4 мянган зөрчил илэрлээ
--------------------------	---

<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө их
-------------------------	----------

**Бодит байдал:****1.Төлөвлөлттэй холбоотой**

Сумын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх "Хороолол дунд зам барих" 439,943.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр ИТХ-аар төсвийг батлуулсан.

Мөн 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний батлагдсан төсөв 434,943.4 байхад өмнөх оноос шилжиж ирсэн 5,000.0 мянган төгрөгийг нэмж 439,943.4 мянган төгрөгөөр тендер зарлаж тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийг дагуу сонгон шалгаруулаагүй байна Үүнд:

- ТШЗ 15.3д Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 оны санхүүгийн тайланг өөрийн тендэртээ хавсарган ирүүлэх,
- ТШЗ-ын 15.2.4д заасан бараа материалын нөөцийн үлдэгдлийг баталгаажуулан ирүүлэх /зураг хавсаргах/ ,
- ТШЗ 15.6.5д Зураг төсвийн үнэ -2 000.0 мянган төгрөг байхад 4,000.0 мянган төгрөгөөр зураг төсвийг ирүүлсэн зэрэг Тендерийн баримт бичгийн шалгууруудыг хангаагүй байна.

**2."ДУК машин худалдан авах" 40,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийн шаардлагыг бүрэн хангаагүй, материал дутуу байна. Үүнд:**

- ТШЗ 18.2д Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа байхгүй
- Худалдан авах ажиллагааны тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулаагүй, (техникийн тодорхойлолтгүйгээр, Foton 30м автомат дизель 3 тонны усны машин, мананцар буутай машины зураг хавсаргасан байна).
- Худалдан авах ажиллагааны тендерийн баримт, бичгийг жишиг баримт бичгийн дагуу ирүүлээгүй, тендэрт оролцогч техникийн тодорхойлолтоос зөрүүтэй машин санал болгосон, мөн ТШЗ 20.2-т заасанаар дүйцэх эсэхээ баримт бичгээр нотлоогүй байхад Мөнхөд бадрах ХХК-нийг шалгаруулж ДУК машин худалдан авах гэрээ байгуулсан.
- Мөнхөд бадрах ХХК-тай 2024 оны 05 сарын 06-ны өдөр байгуулсан гэрээгээр ДУК машин автомашин нийлүүлэх хугацааг 8 дугаар сарын 09-ны өдрийн дотор гэсэн боловч хугацаандаа нийлүүлээгүй, хүлээлгэн өгөөгүй байна.

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "ОНХСийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.3 дах "Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих",

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2."санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх" 26.4.4 "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх", Мөнхөд бадрах ХХК-тай 2024 оны 05 сарын 06-ны өдөр байгуулсан гэрээний 3.1т

<p>"Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид 2024 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгнө", 5.2т "Худалдагч гэрээг гэрээ хийснээс хойш 90 хоногоос хэтрүүлэлгүйгээр хүлээлгэж өгнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна</p>
<p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ТБОНӨХБАУХА тухай хууль болон холбогдох дүрэм журмыг баримталж ажиллаагүй,</li> <li>• ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй,</li> </ul>
<p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсөвт үр ашиггүй зардал үүсэх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх</li> <li>• Аймгийн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх,</li> </ul>
<p><b>Шийдвэр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сумын ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг үндэслэн төсвийг батлуулж байх,</li> <li>• Мөнхөд бадрах ХХК-тай байгуулсан гэрээг цуцалж дахин сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.</li> </ul>

<b>Илэрсэн асуудал 5</b>	Газрын нэгдсэн системд бүртгэлтэй Засаг даргын 2012 оны 70, Засаг даргын 2012 оны А/32, 2023 оны А/33 дугаар захирамжуудаар сумын ЗДТГ-т олгосон эзэмших эрхийн 3 гэрчилгээтэй 31431м <sup>2</sup> газрыг эзэмшигч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө их
<p><b>Бодит байдал:</b> Нягтлан бодох бүртгэлийн хяналтаар биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газрыг, газрын нэгдсэн системийн бүртгэлтэй тулган баталгаажуулахад тус сумын эзэмшлийн дараах газрууд тохирч байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн байгууллагын зориулалттай, 1-р баг, Булаг 2-210 тоотод байршилтай 4304009725 тоот нэгж талбарын дугаар бүхий 4798 м<sup>2</sup> талбай,</li> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, 1-р баг, Найрамдал 5-516 байршилтай 4304000841 тоот нэгж талбарын дугаар бүхий 250 м<sup>2</sup> талбай,</li> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, 1-р баг, Найрамдал 2-244 тоотод байршилтай 4304005296 тоот нэгж талбарын дугаар бүхий 50 м<sup>2</sup> талбай,</li> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, 2-р баг, Булаг 9-902 тоотод байршилтай 4304000839 тоот нэгж талбарын дугаар бүхий 52 м<sup>2</sup> талбай,</li> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, 1-р баг, Булаг 9-901-т байршилтай 4304000837 тоот нэгж талбарын дугаар бүхий 7422м<sup>2</sup> талбай,</li> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай /Хөдөөгийн багийн контор/, 3-р баг, Гүн нуур бригад -1т байршилтай 4304000424 тоот нэгж талбарын дугаар бүхий 395 м<sup>2</sup> талбай,</li> </ul> <p>Харин газрын нэгдсэн системд бүртгэлтэй дараах газрыг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, 2-р баг, Солдат 3-352-т байршилтай 4304000840 тоот нэгж талбарын дугаар бүхий 16382 м<sup>2</sup> талбай, 2012 он</li> <li>• 1-р баг, Найрамдал 4-410 Улаан бургас -22т байршилтай 4304009476 тоот нэгж талбарын дугаар бүхий 50 м<sup>2</sup>, 2018 оны а/32</li> <li>• 3-р баг, Улаан бургас -22т байршилтай 4304011723 тоот нэгж талбарын дугаар бүхий 14999 м<sup>2</sup>, нийт 31431 м<sup>2</sup> эзэмших эрхийн газрыг ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.</li> </ul>	
<p><b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль</p>	

тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын журмыг хэрэгжүүлж ажиллаагүй

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

Газрын бүртгэл, мэдээллийн үнэн зөв байдал нь олон нийтэд төрийн байгууллагын итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг. Данс бүртгэлд тусгахгүй байх нь олон нийтийн итгэл буурахад хүргэж, төрийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлнө болно.

Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх,

**Шийдвэр:**

Сумын ЗДТГ-ын нэр дээрх үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй 31431м2 газрын үнэлгээг журмын дагуу үнэлж бүртгэлд авах, дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**9. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ажил хэргээ арвич хямгач, үр дүнтэй эрхлэн явуулахад сайн зохион байгуулагдсан хяналтын тогтолцоо хэрэгтэй гэдгийг удирдлага ойлгон түүнийг хэрэглэх механизмаа бүрдүүлэх, шийдвэр гаргалтад түүний үр нөлөөг ашиглаж чаддаг байх нь чухал.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 60.0 хувь нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  
ДОТООД АУДИТОР

ТАЙЛАН ХЯНАСАН:  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА, СХИШУАБ, ДОРЖДЭРЭМ  
ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА, СХИШУАБ, ДОРЖДЭРЭМ  
ОТГОНЦОГТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ, Ц.САРАНЦЭЦЭГ

